**НИЙСЛЭЛИЙН**
**ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр Дугаар А/19 Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн 107 дугаар цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 8,645,604.0 /найман сая зургаан зуун дөчин таван мянга зургаан зуун дөрвөн/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Сонгинохайрхан дүүргийн 107 дугаар цэцэрлэг /Б.Ганхуяг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 3 нэр төрлийн 716,496.0 /долоон зуун арван зургаан мянга дөрвөн зуун ерэн зургаан/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 19 нэр төрлийн 7,929,108.0 /долоон сая есөн зуун хорин есөн мянга нэг зуун найман/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сонгинохайрхан дүүргийн 107 дугаар цэцэрлэг /Б.Ганхуяг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг үнэлж, худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Урт цагаан үйлчилгээ, аж ахуйн төв /П.Батжаргал/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 11 өдрийн А/19 тоот тушаалын хавсралт

Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сонгинохайрхан дүүргийн 107 дугаар цэцэрлэг

| Д/д | Эд хөрөнгийн нэр марк | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Машин, тоног төхөөрөмж** | | | | | | | | | | | |
| 1 | Өнгөт принтер | 8 | ш | 2 | 121,000 | 242,000 | 242,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 2 | Видео камер | 9 | ш | 1 | 950,000 | 950,000 | 950,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 3 | Зурагт | 8 | ш | 1 | 120,000 | 120,000 | 120,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 4 | Зурагт | 8 | ш | 1 | 80,000 | 80,000 | 80,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 5 | Зурагт | 6 | ш | 1 | 82,000 | 82,000 | 82,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 6 | Ёочин | 31 | ш | 1 | 13,500 | 13,500 | 13,500 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 7 | Төмс арилгагч | 7 | ш | 1 | 1,010,000 | 1,010,000 | 1,010,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 8 | Хөргүүр | 7 | ш | 1 | 2,000,000 | 2,000,000 | 2,000,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 9 | Пэйч | 9 | ш | 1 | 99,000 | 99,000 | 99,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 10 | Ус буцалгагч | 12 | ш | 1 | 842,490 | 842,490 | 842,490 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 11 | Хөлдөөгч | 5 | ш | 1 | 299,000 | 299,000 | 299,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| Машин, тоног төхөөрөмжмийн дүн | | | | 12 | | 5,737,990 | 5,737,990 | - | | | |
| Тавилга, эд хогшил | | | | | | | | | | | |
| 1 | Алтан булаг хивс | 12 | ш | 1 | 231,990 | 231,990 | 231,990 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 2 | Дрож | 9 | ш | 14 | 27,000 | 378,000 | 378,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 3 | Дрож | 7 | ш | 21 | 40,000 | 840,000 | 840,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 4 | Модон тавиур | 20 | ш | 8 | 32,562 | 260,496 | 260,496 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | устгах |
| 5 | Багш сандал | 9 | ш | 2 | 84,900 | 169,800 | 169,800 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Гал тогооны тавиур | 7 | ш | 1 | 130,000 | 130,000 | 130,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | устгах |
| 7 | Оффис сандал | 9 | ш | 1 | 124,900 | 124,900 | 124,900 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 8 | Сургалтын ширээ | 15 | ш | 10 | 32,600 | 326,000 | 326,000 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | устгах |
| 9 | Түшлэгтэй сандал | 15 | ш | 5 | 13,040 | 65,200 | 65,200 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 10 | Гэр /сургалтын тоглоом/ | 10 | ш | 1 | 305,250 | 305,250 | 305,250 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| 11 | Хүүхдийн ширээ | 31 | ш | 21 | 3,618 | 75,978 | 75,978 | 0.00 | Ашиглахгүй | Актлах | татах |
| **Тавилга, эд хогшлын дүн** | | | | 85 | | 2,907,614 | 2,907,614 | - | | | |
| **Нийт данснаас хасах хөрөнгийн дүн** | | | | 97 | | **8,645,604** | **8,645,604** | - | | | |
| **Татан төвлөрүүлэх хөрөнгө** | | | | | | **7,929,108** | **7,929,108** | - | | | |
| **Актлах хөрөнгө** | | | | | | **716,496** | **716,496** | - | | | |